



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/243

Мандалговь

Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг
бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх
ажил хүлээлцэх комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Гантулга (Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Х.Анхбаяр (Хот тохижуулах газрын дарга)

Гишүүд: С.Бат-Оргил (Сайнцагаан сумын Засаг дарга)

П.Очирбат (Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Тогтохбаяр (“Миний хүлэг” ХХК-ийн захирал)

Хоёр. Дундговь аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээд дэмжлэг үзүүлэх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482061004